



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/232

Хэрлэн сум

**Өвс, худалдан авах ажиллагаанд
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 279, 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай уялдуулан өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 70,2 тонн (234 боодол урлон) өвс нийлүүлэх ажлын гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 50,076,000 (тавин сая далан зургаан мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Гэрээт ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Малыг эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гэрээт ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ